

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2026/108/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

Audit.mn

Хэнтий аймаг

Чингис хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 мэйл хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 мэйл хаяг: Oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энх-Амгалан
Утас: 91119424 мэйл хаяг: Enkh-Amgalang@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа
Утас: 99088151 мэйл хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2026.02.24 № 260

танай _____ -ны № _____ -т

Г ХЭНТИЙ АЙМГИЙН БЭРХ ТОСГОНЫ Г
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ӨЛЗИЙБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын ерөнхий газраас 19,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий иж бүрэн гал тогооны тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлснийг бүртгэлд тусгасан байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангилал бүрээр нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” ангиллаар нэгтгэн төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 21,289.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 21,289.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, үндсэн хөрөнгийн ашиглалт, бүртгэлтэй холбоотой зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний 14 зорилтын хүрээнд 91 арга хэмжээ төлөвлөснөөс гүйцэтгэл 91.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

| Дансны код | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | /төгрөгөөр/ |
|------------|--|-------------------------|-------------------------|
| | | | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 239,181,773.44 | 199,727,584.36 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 125,688,715.52 | 88,788,408.13 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 125,688,715.52 | 88,788,408.13 |
| 31210 | Төгрөг | 125,688,715.52 | 88,788,408.13 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 125,688,715.52 | 88,788,408.13 |
| 33 | АВЛАГА | - | 17,019,726.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 17,019,726.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 113,493,057.92 | 93,919,450.23 |
| 35100 | Түүхий эд материал | 338,000.00 | 130,000.00 |
| 35130 | Эм боох материал | 338,000.00 | 130,000.00 |
| 35400 | Хангамжийн материал | 113,155,057.92 | 93,789,450.23 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,722,100.00 | 961,600.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,456,395.00 | 20,753,870.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 16,862,300.00 | 1,043,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 10,848,760.00 | 9,610,359.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 63,265,502.92 | 61,420,621.23 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,006,479,699.43 | 4,833,835,637.79 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 4,006,479,699.43 | 4,833,835,637.79 |
| 39200 | Биет хөрөнгө | 3,919,327,699.43 | 4,746,683,637.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,174,054,820.08 | 5,092,762,581.08 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (557,252,541.98) | (696,868,008.98) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 544,299,356.39 | 479,474,184.36 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (287,352,715.77) | (269,069,064.64) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 139,137,354.42 | 181,067,876.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (93,558,573.71) | (40,683,930.13) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,071,500.00 | 3,200,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,071,500.00) | (3,200,000.00) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 87,152,000.00 | 87,152,000.00 |
| 39301 | Програм хангамж | 1,580,000.00 | 1,580,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,580,000.00) | (1,580,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 87,152,000.00 | 87,152,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 4,245,661,472.87 | 5,033,563,222.15 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 58,435,435.00 | 37,186,185.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 58,435,435.00 | 37,186,185.00 |
| 41300 | Өглөг | 58,435,435.00 | 37,186,185.00 |
| 41360 | Бусад өглөг | 58,435,435.00 | 37,186,185.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 58,435,435.00 | 37,186,185.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,187,226,037.87 | 4,996,377,037.15 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,187,226,037.87 | 4,996,377,037.15 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 473,462,245.07 | 473,462,245.07 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 473,462,245.07 | 473,462,245.07 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 2,515,919,381.70 | 3,325,070,380.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,605,558,743.02 | 2,515,919,381.70 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (89,639,361.32) | 809,150,999.28 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,197,844,411.10 | 1,197,844,411.10 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 4,245,661,472.87 | 5,033,563,222.15 |

Хэнтий аймгийн Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|------------|---|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 2,230,866,067.40 | 3,556,800,764.89 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 511,811,267.40 | 3,556,800,764.89 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 115,833,667.40 | 1,069,342,764.89 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,051,700.00 | 2,030,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,883,700.00 | 40,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 168,000.00 | 1,990,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 66,976,980.00 | 1,046,184,446.58 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 45,804,987.40 | 21,128,318.31 |
| 122 | Тусламжийн орлого | - | 2,487,458,000.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 2,048,153,800.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 2,048,153,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\Улсын төсөв\ | - | 2,048,153,800.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\Орон нутаг\ | | 439,304,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,719,054,800.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,719,054,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,719,054,800.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,924,527,828.72 | 2,368,295,950.94 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,924,527,828.72 | 2,368,295,950.94 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,872,839,328.72 | 2,228,773,065.61 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,345,048,366.08 | 1,621,135,793.00 |
| 210101 | Үндсэн цалин | 834,794,548.42 | 962,326,304.62 |
| 210102 | Нэмэгдэл | 469,788,765.74 | 594,180,999.93 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 22,149,058.74 |
| 210104 | Урамшуулал | 40,465,051.92 | 42,479,429.71 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 166,906,160.14 | 203,171,408.53 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 113,159,838.00 | 138,980,108.52 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 13,429,167.84 | 16,163,239.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 7,331,898.84 | 8,240,030.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 6,203,163.68 | 7,957,565.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 26,782,091.78 | 31,830,463.53 |
| 2105 | Нормативт зардал | 39,756,200.00 | 59,636,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,756,200.00 | 59,636,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,494,500.00 | 17,696,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,494,500.00 | 17,696,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,117,811.95 | 16,467,420.86 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,883,700.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 22,234,111.95 | 16,467,420.86 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 286,516,290.55 | 310,666,343.22 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 54,823,507.00 | 65,688,285.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,806,200.00 | 6,249,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 219,886,583.55 | 238,728,508.22 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 51,688,500.00 | 139,522,885.33 |
| 2131 | Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | 59,950,385.33 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 59,950,385.33 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 51,688,500.00 | 79,572,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 51,688,500.00 | 79,572,500.00 |

Хэнтий аймгийн Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|-----|--|-----------------|----------------|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (89,639,361.32) | 809,150,999.28 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | (89,639,361.32) | 809,150,999.28 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|-------------|---|----------------------|----------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 1,722,106,500.0 | 2,489,488,000.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 3,051,700.0 | 2,489,488,000.0 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 3,051,700.0 | 2,030,000.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,051,700.0 | 2,030,000.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,883,700.0 | 40,000.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 168,000.0 | 1,990,000.0 |
| 122 | Тусламжийн орлого | - | 2,487,458,000.0 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 2,048,153,800.0 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 2,048,153,800.0 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого/Улсын төсөв/ | - | 2,048,153,800.0 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого/Орон нутаг/ | - | 439,304,200.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,719,054,800.0 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,719,054,800.0 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,115,032,400.0 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,099,018,834.9 | 2,506,488,307.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,099,018,834.9 | 2,506,488,307.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,049,433,204.9 | 2,369,950,322.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,343,664,914.5 | 1,638,155,519.0 |
| 210101 | Үндсэн цалин | 833,411,096.8 | 979,346,030.6 |
| 210102 | Нэмэгдэл | 469,788,765.7 | 594,180,999.9 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 22,149,058.7 |
| 210104 | Урамшуулал | 40,465,051.9 | 42,479,429.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 168,289,611.8 | 203,171,408.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 114,543,283.6 | 138,980,108.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 13,429,167.8 | 16,163,239.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 6,844,453.5 | 8,240,030.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 6,690,615.0 | 7,957,565.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 26,782,091.8 | 31,830,463.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой зардал | 365,854,394.7 | 369,353,814.7 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 16,815,382.2 | 21,743,309.7 |
| 210302 | Халаалт | | |
| 210303 | Цэвэр бохир ус | 22,443,960.0 | 22,827,640.0 |
| 2105 | Нормативт зардал | 44,300,600.0 | 61,382,599.0 |
| 210502 | Хоол, хүнс | 44,300,600.0 | 61,382,599.0 |
| 2106 | Эд хогшил урсгал засварын зардал | 25,124,300.0 | 10,000,000.0 |
| | Урсгал зардал | 25,124,300.0 | 10,000,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 27,718,612.0 | 24,088,720.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,883,700.0 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 24,834,912.0 | 24,088,720.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 74,480,772.0 | 63,798,260.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 61,860,472.0 | 55,075,160.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,620,300.0 | 8,723,100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 49,585,630.0 | 136,537,985.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 49,585,630.0 | 76,587,600.0 |

Хэнтий аймгийн Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|----------------|----------------|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 49,585,630.0 | 76,587,600.0 |
| 213112 | Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал | | 59,950,385.3 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 59,950,385.3 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 14,066,359.8 | (17,000,307.4) |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 23,601,000.0 | 19,900,000.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 23,601,000.0 | 19,900,000.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 23,601,000.0 | 19,900,000.0 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,601,000.0 | 19,900,000.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (23,601,000.0) | (19,900,000.0) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | (9,534,640.2) | (36,900,307.4) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 135,223,355.7 | 125,688,715.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 125,688,715.5 | 88,788,408.1 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 473,462,245.07 | 1,197,844,411.10 | 2,515,919,381.70 | 4,187,226,037.87 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 473,462,245.07 | 1,197,844,411.10 | 2,515,919,381.70 | 4,187,226,037.87 |
| C08 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 473,462,245.07 | 1,197,844,411.10 | 2,515,919,381.70 | 4,187,226,037.87 |
| D01 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 473,462,245.07 | 1,197,844,411.10 | 2,515,919,381.70 | 4,187,226,037.87 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 473,462,245.07 | 1,197,844,411.10 | 2,515,919,381.70 | 4,187,226,037.87 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 809,150,999.28 | 809,150,999.28 |
| D09 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 473,462,245.07 | 1,197,844,411.10 | 3,325,070,380.98 | 4,996,377,037.15 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|------------|--|-----------------|-----------------|--------------|--------|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 2,518,351,900.0 | 2,429,537,614.7 | 88,814,285.3 | 96.47 |
| 12 | Татварын бус орлого | 2,518,351,900.0 | 2,429,537,614.7 | 88,814,285.3 | 96.47 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,990,000.0 | 2,030,000.0 | (40,000.0) | 102.01 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | - | 40,000.0 | (40,000.0) | |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 1,990,000.0 | 1,990,000.0 | - | 100.00 |
| 122 | Тусламжийн орлого | 2,516,361,900.0 | 2,427,507,614.7 | 88,854,285.3 | 96.47 |

Хэнтий аймгийн Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|---|------------------------|------------------------|----------------------|--------------|
| 122005 | Төсвөөс санхүүжих | 2,077,057,700.0 | 2,048,153,800.0 | 28,903,900.0 | 98.61 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 439,304,200.0 | 379,353,814.7 | 59,950,385.3 | 86.35 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,644,040,200.0 | 2,466,437,922.1 | 177,602,277.9 | 93.28 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,644,040,200.0 | 2,466,437,922.1 | 177,602,277.9 | 93.28 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,564,183,300.0 | 2,389,850,322.1 | 174,332,977.9 | 93.20 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,732,252,900.0 | 1,638,155,519.0 | 94,097,381.0 | 94.57 |
| 210101 | Үндсэн цалин | 1,065,987,200.0 | 979,346,030.6 | 86,641,169.4 | 91.87 |
| 210102 | Нэмэгдэл | 646,375,200.0 | 594,180,999.9 | 52,194,200.1 | 91.93 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 22,149,058.7 | (22,149,058.7) | |
| 210104 | Урамшуулал | 19,890,500.0 | 42,479,429.7 | (22,588,929.7) | 213.57 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 216,531,700.0 | 203,171,408.5 | 13,360,291.5 | 93.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 147,241,600.0 | 138,980,108.5 | 8,261,491.5 | 94.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 17,322,500.0 | 16,163,239.7 | 1,159,260.3 | 93.31 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,661,300.0 | 8,240,030.8 | 421,269.2 | 95.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,661,300.0 | 7,957,565.9 | 703,734.1 | 91.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 34,645,000.0 | 31,830,463.5 | 2,814,536.5 | 91.88 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 390,978,694.7 | 379,353,814.7 | 11,624,880.0 | 97.03 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 16,815,382.2 | 21,743,309.7 | (4,927,927.5) | 129.31 |
| 210302 | Халаалт | 326,595,052.5 | 324,782,865.0 | 1,812,187.5 | 99.45 |
| 210303 | Цэвэр бохир ус | 22,443,960.0 | 22,827,640.0 | (383,680.0) | 101.71 |
| 2105 | Нормативт зардал | 66,829,600.0 | 61,382,599.0 | 5,447,001.0 | 91.85 |
| 210502 | Хоол, хүнс | 66,829,600.0 | 61,382,599.0 | 5,447,001.0 | 91.85 |
| 2106 | Эд хогшил урсгал засварын зардал | 25,124,300.0 | 10,000,000.0 | 15,124,300.0 | 39.80 |
| 210604 | Урсгал засвар | 25,124,300.0 | 10,000,000.0 | 15,124,300.0 | 39.80 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,486,100.0 | 24,088,720.9 | 1,397,379.1 | 94.52 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 25,486,100.0 | 24,088,720.9 | 1,397,379.1 | 94.52 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,778,800.0 | 83,698,260.0 | 80,540.0 | 99.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 75,055,700.0 | 74,975,160.0 | 80,540.0 | 99.89 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,723,100.0 | 8,723,100.0 | - | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 79,856,900.0 | 76,587,600.0 | 3,269,300.0 | 95.91 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 79,856,900.0 | 76,587,600.0 | 3,269,300.0 | 95.91 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 79,856,900.0 | 76,587,600.0 | 3,269,300.0 | 95.91 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | (125,688,300.0) | (36,900,307.4) | (88,787,992.6) | 29.36 |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 125,688,300.0 | 36,900,307.4 | 88,787,992.6 | 29.36 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 125,688,300.0 | 36,900,307.4 | 88,787,992.6 | 29.36 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 125,688,715.5 | (125,688,715.5) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 88,788,408.1 | (88,788,408.1) | - |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,289.4 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс, 21,289.4 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

1. Ур чадварын нэмэгдлийг хагас жил тутам холбогдох шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж нэмэгдэл олгодог, журмын дагуу олгоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”, “сумын түвшинд 15 хувь,” аймаг, нийслэлийн түвшинд 20 хувь,” улс, бүс, олон улсын амжилт гаргасан түвшинд 25 хувь,” гэсэн заалтуудыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

2. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.1-д "бие даасан байх", 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1. "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчиж, "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн. Биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх

3.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 61 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т “Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1.”Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хэнтий аймгийн Бэрх тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж, шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|-----------------|---------------|-----|-----------------|-----------------|----------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Ур чадварын нэмэгдлийг хагас жил тутам холбогдох шалгуур үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж нэмэгдэл олгодог, журмын дагуу олгоогүй байна. | 1 | 21,289.4 | | | 1 | 21,289.4 | | | | | | |
| Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 61 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 3 | 21,289.4 | | | 2 | 21,289.4 | 1 | | | | | |